

„БНЧУ-д Фоксконн байгуулагдсаны 25 жилийн ой” сэдэвт уралдааны дүрэм: Мэдлэгээ сорьж шагнал хожоорой!”

2025.8.1. – 2025.8.31.

Энэхүү дүрэм нь (цаашид зөвхөн “**Дүрэм**” гэх) „БНЧУ-д Фоксконн байгуулагдсаны 25 жилийн ой” сэдэвт „Мэдлэгээ сорьж шагнал хожоорой!” уралдааныг (цаашид зөвхөн “**Уралдаан**” гэх) зохицуулна.

1. Уралдааны зохион байгуулагч

- 1.1 Уралдааны зохион байгуулагч нь Foxconn European Manufacturing Services s.r.o. компани, УБД: 25965361, хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, Храдэц Краловэ хот дахь Мужийн шүүхэд хөтлөгддөг Бизнес үйл ажиллагааны бүртгэлийн С хэсгийн 17934 дугаарт бүртгэлтэй (цаашид зөвхөн „Зохион байгуулагч” гэх).
- 1.2 Уралдааныг JOBKa (dále jen „**JOBKa**”) аппликашнаар явуулна.

2. Хугацаа, байршил

- 2.1 Уралдаан **2025.8.1. – 2025.8.31**-нд явагдана (цаашид зөвхөн „**Уралдааны хугацаа**”).
- 2.2 Уралдаан БНЧУ-ын нутаг дэвсгэрт JOBKa аппликэшнээр явагдана.

3. Уралдаанд оролцох нөхцөл

- 3.1 Уралдаанд оролцогч нь зөвхөн **Фоксconn группын ажилтан** (энэхүү дүрмийн 8.1 зүйлийг үзнэ үү) байх бөгөөд **15-аас дээш насны, Чех улсад оршин суух хаягтай**, энэхүү Дүрмийн бүхий л нөхцөлийг биелүүлж буй хүн (цаашид зөвхөн „**Уралдаанд оролцогч**”) байх ёстой.
- 3.2 Уралдаанд оролцогч бүр Уралдаанд зөвхөн **нэг удаа** оролцох эрхтэй, ө.х. Уралдаанд зөвхөн нэг материал (Дүрмийн 4.3. үз) илгээх ёстой.
- 3.3 Уралдаанд сайн дураар оролцоно. Уралдаанд оролцож эхэлбэл уралдааны энэхүү Дүрмийг зөвшөөрч, түүнийг баримтлах үүрэгтэй болно. Уралдаанд оролцогч түүнчилэн JOBKa аппликэшны бүхий л дүрмийг, ялангуяа түүнийг ашиглах, мөрдөх бүх дүрмийг баримтлах үүрэгтэй.
- 3.4 Уралдаанд оролцох нөхцөл нь бараа үйлчилгээ худалдан авах эсвэл өөр ямар нэг төлбөр хийхтэй хамаарахгүй.

4. Уралдааны зарчим

- 4.1 Уралдаан эхэлсэн эхний өдөр Зохион байгуулагч (бүлэг 2.1) JOBKa аппликэшнээр уг уралдааны талаарх танилцуулга, асуулт зэргийг оруулж Уралдаанд оролцохыг уриална.
- 4.2 Уралдаанд оролцогч Уралдаанд дараах байдлаар оролцоно:

Уралдаанд оролцогч Уралдааны хугацаанд (бүлэг 2.1) JOBKa аппликэшн дээр гарсан пардубицийн болон кутнохорагийн холбогдолтой 16 асуулт тус бүрд зөв хариулж оролцоно. Уралдаанд оролцогч эдгээр бүх нөхцөлийг (цаашид зөвхөн “**Уралдааны хариулт**” гэх) биелүүлэх ёстой.

- 4.3 **Нэг оролцогч Уралдаанд зөвхөн нэг хариулт илгээх ёстой.**

4.4 Уралдааны хариултын агуулгыг Уралдаанд оролцогч бүрэн хариуцна. Ингэхдээ дараах шаардлагыг хангана:

- a) Уралдааны хариулт хүчин төгөлдөр бүхийн хууль журмуудтай зөрчилдөхгүй байх;
- b) Уралдаанд оролцогч хэрэглэх ашиглах эрхгүй хувийн мэдээлэл, зураг бичлэг зэргийг Уралдааны хариултад оруулж болохгүй;
- c) Уралдааны хариултад хүний нэр төрийг гутаан доромжилсон, ёс зүй, зан суртахууны зөв хэм хэмжээтэй зөрчилдөх (ялангуяа садар самуун, хүчирхийлэл сурталчилсан, үндэс угсаа, гарал үүслийг доромжилсон, гэмт хэрэг, зүй бус хэрэгт чиглэсэн) ямар ч зохисгүй зүйлийг оруулахгүй байх ёстой;
- d) Уралдааны хариултад гуравдагч этгээдийн эрх ашгийг хөндсөн, ялангуяа зохиогчийн эрх, барааны тэмдэгт, бүтээгдэхүүний гарал үүсэл зэрэг бүтээгдэхүүний болон оюуны өмчийн бусад эрхэд халдсан зүйл оруулж болохгүй;
- e) Уралдааны хариултад аливаа зүйлийг далд утгаар сурталчилсан зүйл оруулж болохгүй;
- f) Уралдааны хариулт нь ямар ч хэлбэрээр Уралдаан зохион байгуулагч болон бусад этгээдийн нэр хүндэд халдаж болохгүй.

4.5 Зохион байгуулагч нь эдгээр дүрэмд заасан шаардлагыг хангаагүй Уралдаанд оролцогчийг Уралдаанд оруулахгүй байх, эсвэл ямар ч шалтгаангүйгээр Уралдаанаас хасах эрхтэй бөгөөд үүнд ямар нэгэн нөхөн төлбөр олгохгүй. Гэхдээ зохион байгуулагч нь тогтмол хянах үүрэггүй бөгөөд Уралдаанд оролцогч эдгээр нөхцөлийг зөрчсөнд хариуцлага хүлээхгүй.

4.6 Уралдааны зохион байгуулагч JOBka аппликэшнтэй холбоотой техникийн саатал, харилцааны саатлыг хариуцахгүй.

5. Уралдааны шагнал болон ялагчийг шалгаруулах хэлбэр

5.1 Уралдааны шагнал нь дараах зүйлс байна:

Alza.cz дэлгүүрээс 1000 кроны үнэ бүхий зүйл авах эрхий бичиг 10 ш.

5.2 Зохион байгуулагч нийтэл ил бүс сугалаагаар Ялагчийг шалгаруулна. **Бүрэн бөгөөд зөв хариулсан** Уралдаанд оролцогсдоос шагнал олгох эрхийн бичгийн тоогоор (**бүлэг 5.1**) сугална, уралдаанд оролцогч нэг хүн дээд тал нь нэг шагнал авах боломжтой.

6. Уралдааны дүнг танилцуулах, шагнал гардуулах

6.1 Уралдаанд Ялагчаар тодорсон (цаашид “Ялагч” гэх) оролцогчтой Зохион байгуулагч **2025.9.20-ны дотор JOBka аппликэшнээр мэдээ дамжуулан** холбогдоно.

6.2 Ялагчийн шагналыг MyFox системд эрхийн бичгийн кодыг нь оруулан дамжуулна.

6.3 Уралдааны шагнал нь бэлгийн журмаар өгөгдөх бөгөөд бүтээгдэхүүний чанар, гологдол зэрэгт Уралдаан зохион байгуулагч хариуцлага хүлээхгүй.

6.4 Ялагч нь зохион байгуулагчид өөрийн зургаа авахыг зөвшөөрч, эдгээр зурагнуудыг дараа нь боловсруулж, хэвлэл мэдээллийн арга хэрэгслээр, ялангуяа зохион байгуулагчийн компанийн дотор, вэбсайт болон нийгмийн сүлжээгээр (жишээ нь Facebook, Instagram, LinkedIn, X, YouTube, TikTok) нийтлэхийг зөвшөөрч байна. Зураг авах нь үнэгүй бөгөөд шагнал гардуулахад шаардагдахгүй түл ялагч нь өөрийн зургийг авахуулахаас татгалзаж болно.

6.5 Зохион байгуулагч нь Ялагчид шалгарсан тухай илгээсэн мэдээлэл алдагдсан, гэмтсэн, устсан эсвэл шагналын зүйл Ялагчид илгээгдэхдээ алдагдсан, гэмтсэн, устсан зэрэг шалтгаан нь Уралдаанд оролцогчийн, хүргэгч үйлчилгээний албаны, эсвэл цахим холбооны үйлчилгээний газрын зүгээс үүдэлтэй бол Зохион байгуулагч хариуцлага хүлээхгүй.

- 6.6 Шүүх байгууллагад заргалдах замаар шагналын зүйлийг олж авах боломжгүй. Уралдаанд оролцогч шагналын зүйлийг өөр шагналаар авах боломжгүй. Шагналын зүйлийг бэлэн мөнгөөр эсвэл өөр зүйлээр орлуулах боломжгүй.
- 6.7 Шагналын дүн нь Ялагчид шагнал олгогдох тухайн сарын татвар бодогдох суурь цалинд багтана, гэдгийг Уралдаанд оролцогч ойлгож байна.

7. Хувийн мэдээлэл боловсруулалт

- 7.1 Зорилго, хэлбэрүүд. Уралдаанд оролцогч нь Уралдаанд оролцохдоо Зохион байгуулагч хувийн мэдээллийг нь боловсруулж байгаа тухай мэдэж байгаа бөгөөд энэ нь уг Уралдаанд эдгээр дүрмүүдийн дагуу хэрэглэх, Уралдааны удирдлага, зохион байгуулалт, шалгаруулалт (түүнчлэн сугалаа) болон ялагчтай холбогдох зорилгоор байна. Уралдаанд оролцогч нь хэрэв тухайн нийгмийн сүлжээнд уг Уралдаан явагдаж байгаа бол Уралдааны хариулт, нэр овог /эсвэл хэрэглэгчийн нэрийг тухайн нийгмийн сүлжээнд нийтлэхийг зөвшөөрч байна. Зохион байгуулагч эдгээр хувийн мэдээллийг нэр, овог болон/эсвэл хэрэглэгчийн нэрийг тухайн нийгмийн сүлжээнд боловсруулж, зохион байгуулагчийн компанийн дотоод мэдээлэл, вэбсайтуудад болон нийгмийн сүлжээнүүдээр (жишээ нь Facebook, Instagram, LinkedIn, X, YouTube, TikTok) гаргана. Хэрвээ Уралдаанд оролцогчийн зураг байгаа бол зохион байгуулагч тухайн зургийг боловсруулж хэрэглэхийг Уралдаанд оролцогч зөвшөөрч байна. Хувийн мэдээллийг боловсруулах нь Уралдааныг зохион байгуулахад шаардлагатай юм. Ялагчийн зураг, нэр овог, эсвэл нийгмийн сүлжээнд хэрэглэгддэг нэрийг тухайн нийгмийн сүлжээнд боловсруулж, сурталчилгаа хийх зорилгоор, мөн дотоод бүртгэл статистикийн зорилгоор хэрэглэж боловсруулна.
- 7.2 Хэрэглэх хугацаа. Зохион байгуулагч нь Уралдаанд оролцогчдын болон ялагчдын хувийн мэдээллийг зөвхөн зайлшгүй шаардлагатай хугацаагаар боловсруулна, үүнд Уралдааны хугацаа (2.1 зүйл) болон Уралдааны нөхцөлийг шалгах, шагнал гардуулах зорилгоор 3 сарын хугацаанд боловсруулна. Уралдаан дууссанаас хойш 5 жилийн хугацаанд зохион байгуулагч нь өрсөлдөгчдийн нэр, овог болон/эсвэл хэрэглэгчийн нэрийг дотоод статистик зорилгоор боловсруулна. Уралдааны хариулт, зураг болон ялагчийн нэр, овог нь зохион байгуулагчийн зүгээс нийтлэг арга хэрэгслээр нийтлэгдэж болох бөгөөд зохион байгуулагч энэ мэдээллийг устгах хүртэл нийтлэгдэж байх болно (Уралдаанд оролцогчод энэ мэдээллийг устгуулахыг ямар ч үед хүсэж болно). Ялагчдын бичлэгүүд, нэр, овог /эсвэл хэрэглэгчийн нэрийг нийгмийн сүлжээгээр, тэр дундаа Foxconn группийн компаниудын дотор, "Živý Foxconn" компанийн сэтгүүл, вэбсайтууд болон нийгмийн сүлжээнүүдээр (жишээ нь Facebook, Instagram, LinkedIn, X, YouTube, TikTok) нийтлэх боломжтой бөгөөд зохион байгуулагч эдгээр мэдээллийг устгах хүртэл байх болно (уралдаанд оролцогчод энэ мэдээллийг устгуулахыг ямар ч үед хүсэж болно).
- 7.3 Bezpečnost a soulad s předpisy. Аюулгүй байдал ба дүрмийн хяналт. Зохион байгуулагч нь эдгээр нөхцлийн дагуу хувийн мэдээллийг боловсруулж байхдаа хувийн мэдээллийн аюулгүй байдлын талаар, ялангуяа Европын парламент болон Европын холбооны зөвлөлийн “Хувийн мэдээлэлтэй харьцахтай холбоотойгоор хувь хүнийг хамгаалах болон мэдээллийн чөлөөт хөдөлгөөний тухай болон 95/46/ES тоот удирдамжийг цуцлах тухай” 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн 2016/679 тоот захирамж (хувийн мэдээлэл хамгаалах тухай ерөнхий журам, цаашид зөвхөн GDPR гэх) болон хууль эрхзүйн зохих барим бичгийг баримталж мөрдөх болно, мөн хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй, эсвэл санамсаргүйгээр хандах, өөрчлөх, устгах, алдах, зөвшөөрөлгүй шилжүүлэх, зөвшөөрөлгүй боловсруулалт хийх болон бусад төрлийн хууль бус ашиглалтаас хамгаалахын тулд зохих арга хэмжээ авахыг амлаж байна.
- 7.4 Зохион байгуулагч нь Уралдаанд оролцогчийн хувийн мэдээллийг шууд маркетинг эсвэл профайл хийх зорилгоор боловсруулдаггүй бөгөөд хувийн мэдээллийг гуравдагч оронд дамжуулахгүй.
- 7.5 Оролцогчийн эдлэх эрх. Уралдаанд оролцогч бүр хувийн мэдээллээ хамгаалах үүднээс зохих хууль журмын дагуу ялангуяа дараах эрхүүдийг эдлэнэ:

- a) Хувийн мэдээлэлдээ нэвтрэх эрх – түүнийг боловсруулж буй арга явцтай танилцах, хувийн мэдээлэл хүлээж авагсад, хадгалах хугацаа, эх үүсвэр зэргийн талаарх мэдээллийг авах эрхтэй;
- b) Бүрүү мэдээллээ засаж залруулахыг хүсэх эрхтэй;
- c) хувийн мэдээллээ устгуулах эрхтэй;
- d) хувийн мэдээллийн боловсруулалтыг хязгаарлах эрхтэй, хувийн мэдээлэл бүрүү байвал, боловсруулалт нь эрх зөрчсөн байвал уг хувийн мэдээллийг устгуулахгүй, харин түүний ашиглалтыг хязгаарлах, Хувийн мэдээллүүдийг боловсруулах хэрэггүй болсон ч та хууль ёсны эрхийнхээ дагуу өмгөөлөлт, тодорхойлолт, тодорхой үйлдэлд хэрэглэхийг хүсэх;
- e) хувийн мэдээллээ боловсруулахыг эсэргүүцэх эрх;
- f) хувийн мэдээлэл нь гэрээ зөвшөөрлийн үндсэн дээр бүтэцжсэн, түгээмэл хэрэглэгддэг төхөөрөмж дээр цахим хэлбэрээр боловсруулагдсан бол автомат аргаар дамжуулж хүлээж авахыг хүсэх эрхтэй;
- g) Хувийн мэдээлэлтэй харьцах зөвшөөрлөө цуцлах эрх; Гэхдээ зөвшөөрлөө цуцлахаас тань өмнө хийгдсэн хувийн мэдээллийн боловсруулалт үүнд хамаарахгүй;
- h) Хувийн мэдээллийг хамгаалах албанд гомдол гаргах эрхтэй (хаяг: Úřad pro ochranu osobních údajů, se sídlem Pplk. Sochora 727/27, 170 00 Praha 7 – Holešovice)..

Мэдээллийн субъект ерөнхийдөө өөрийн хувийн мэдээллээ өгөхгүй байх эрхтэй. Гэхдээ зарим тохиолдолд хувийн мэдээлэл нь гэрээ байгуулахад шаардагдаж болно. Хэрэв ийм тохиолдолд хувийн мэдээллийг өгөөгүй бол гэрээ байгуулах болон түүнийг гүйцэтгэх боломжгүй болно. Хэрэв хувийн мэдээллийг боловсруулах шаардлага хуульд үндэслэгдэж байвал, эдгээр хувийн мэдээллийг өгөхгүй байх үр дагавар нь хууль тогтоомжийн дагуу байна.

Зохион байгуулагч нь энэ Уралдаантай холбогдуулан хувийн мэдээллийг автоматжуулсан буюу гар аргаар боловсруулдаг. Автоматжуулсан шийдвэр гаргалт (тодруулбал, зөвхөн автоматжуулсан хувийн мэдээлэл боловсруулахад тулгуурласан шийдвэр гаргалт) болон түүний профайл хийх үйл явц хийгддэггүй.

- 7.6 Зохион байгуулагчтай холбогдох хаяг, гомдол санал. Хувийн мэдээлэлтэй харьцаж буйтай холбоотой Зохион байгуулагчийн үйл ажиллаганы талаарх гомдлыг Зохион байгуулагчийн байрлах хаяг дээрх компанийн Compliance хэлтэст ирж өгөх, эсвэл дараах хаягаар имэйл бичиж болно: GDPRInfo@emea.foxconn.com . Энэхүү хаягаар Уралдаанд оролцогч нь зохион байгуулагчид гомдол, хүсэлт, шүүхийн маргаан эсвэл бусад асуулгуудыг тавьж болно. Хувийн мэдээллийн хамгаалалтын салбарт хяналт тавих байгууллага нь Чехийн Хувийн мэдээллийн хамгаалалтын алба юм.
- 7.7 Зохион байгуулагч нь нийгмийн сүлжээний үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдээллийг боловсруулахад хариуцлага хүлээхгүй – энэ мэдээллийн боловсруулалт нь холбогдох үйл ажиллагаа эрхлэгчийн нөхцөлүүдэд нийцнэ. (www.instagram.com, www.facebook.com, г.м.).

8. Төгсгөл

8.1 Энэхүү дүрмийг баримтлах Фоксконн Групп гэдэг нь дараах байгууллагууд юм:

- a) Foxconn European Manufacturing Services s.r.o., хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, IČO: 25965361,
- b) Foxconn Technology CZ s.r.o., хаяг: Karlov 245, 284 01 Kutná Hora, IČO: 27516032,
- c) FOXCONN CZ s.r.o., хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, IČO: 25938002,
- d) GLOBAL SERVICES SOLUTIONS s.r.o., хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, IČO: 27524850.
- e) SafeDX s.r.o., хаяг: K Žižkovu 813/2, Vysočany, 190 00 Praha 9, IČO: 04585119,
- f) Foxteq CZ s.r.o., хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, IČO: 17405459.

8.2 Энэхүү Дүрэм нь Уралдаанд зориулсан цорын ганц бөгөөд бүрэн дүрэм гэж тооцогддог. Энэ Дүрмийн хэсгийг нийтлэх эсвэл энэ Дүрмийн холбоосыг оруулах тохиолдолд, үргэлж энэхүү Дүрэм бүрэн утгаар хэрэгжинэ.

- 8.3 Энэхүү Дүрмийг myfoxconn.cz вэбсайтад цахим хэлбэрээр нийтэлсэн бөгөөд зохион байгуулагчийн төв оффис (1.1 заалт)-д бичмэл хэлбэрээр хамгийн багадаа Уралдаан явагдаж байх хугацааны туршид хадгалагдах болно.
- 8.4 Зохион байгуулагч нь Уралдааныг зохион байгуулах, явуулахтай холбоотой бүх асуудалд эцсийн шийдвэр гаргах эрхтэй бөгөөд үүнд Уралдааныг зогсоох, хойшлуулах, цуцлах, эрт дуусгах эсвэл энэ Дүрмийг өөрчлөх эрхтэй. Зохион байгуулагч нь Уралдаан явагдаж байх үед эдгээр дүрмүүдийг өөрчлөх, үүнд Уралдаанд оролцогчдыг тодруулах арга, шагналын төрөл ба хэмжээ, мөн онцгой тохиолдолд Уралдааныг цуцлах боломжтой. Зохион байгуулагч нь Уралдааны явцад Уралдаанд оролцогчдод шагнал олгохоос татгалзах эрхтэй, ялангуяа хэрэв Уралдаанд оролцогч нь Уралдааны дүрмийг зөрчсөн эсвэл тийм оролдлого хийсэн гэж Зохион байгуулагч сэжиглэж байвал ийм шийдвэр гаргаж болох бөгөөд Зохион байгуулагч нь Уралдаанд оролцогчийг уралдаанаас хасах эрхтэй бөгөөд ямар ч нөхөн төлбөр олгох үүрэггүй. Маргаантай асуудал дээр эцсийн шийдвэр гаргах эрх нь үргэлж зохион байгуулагчид байна.